

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ АСУУДЛААР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС  
ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Г.Баярсайхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж Улсын Их Хурлын гишүүн Су.Батболдыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Су.Батболд нь Хөдөө аж ахуйн дээд сургууль, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийг төгссөн. Инженер-багш, эрх зүйч мэргэжилтэй. Техникийн ухааны магистр (MA), Удирдахуйн ухааны доктор (Ph.D) зэрэгтэй.

Тэрээр 2004-2005 онд Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, 2005-2006 онд Засгийн Газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, 2006-2007 онд Засгийн Газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, 2011-2012 онд Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дэд дарга зэрэг албан тушаалуудыг хашиж байсан бөгөөд 2002 оноос өнөөг хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Су.Батболдыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны даргаар сонгохыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар гарсан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.БАЯРСАЙХАН**